

Ерөөлийн үгс

ШИНЭ ГЭРЭЭНИЙ СЕМИНАРЫН МАТЕРИАЛ

Эшлэл	Зан чанар
Матай 5:3; 3 Нифай 12:3	Сүнсэндээ ядуу байх. Даруу байх эсвэл “Их Эзэнээс хамааралтай гэдгээ талархан хүлээн зөвшөөрч, Түүний дэмжлэг туслалцаа байнга хэрэгтэй болохыг ойлгох явдал юм. Даруу байдал бол бидний авьяас билиг, ур чадвар Бурханаас ирсэн бэлэг хэмээн хүлээн зөвшөөрөхийг хэлнэ” (Сайн мэдээний сэдвүүд, “Даруу байдал,” topics.ChurchofJesusChrist.org).
Матай 5:4	Гашуудах. Энэ нь ямар нэг зүйлийн талаар зовж шаналж, үүнийг илэрхийлэхийг хэлнэ. Хүн өөрт нь болон бусдад тулгарсан мөнх бус амьдралын сорилтод гашуудаж болно. Үүнтэй адил, хүн бас нүглийн шаналлаас болж гашуудаж болно.
Матай 5:5	Номхон дөлгөөн байх. “Бурханаас айдаг, зөв зүйтэй, даруу, сургаал авдаг бөгөөд шаналалд тэвчээртэй” байх [Судруудын удирдамж, ‘Номхон дөлгөөн, номхон дөлгөөн байдал,’ scriptures.ChurchofJesusChrist.org]. Ийм хүмүүс Есүс Христийг дагах хүсэлтэй байх ба тэдний зан байдал тайван, номхон дөлгөөн байдаг” (Улиссэс Соарэс, “Хүлцэнгүй даруу мөн зүрх сэтгэлдээ номхон байгтун,” <i>Ensign</i> , Nov. 2013, 9 эсвэл 2013 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 9).
Матай 5:6; 3 Нифай 12:6	Зөв шударгын төлөө өлсөж, цангах. Бурханы тааллыг таньж мэдэн, үүний дагуу үйлдэх агуу хүсэлтэй байх.
Матай 5:7	Өршөөнгүй байх. “Бусдын дутагдлыг мэдэж байсан ч энэрэнгүй, хүндэтгэлтэй, уучлахад бэлэн, зөөлөн бөгөөд тэвчээртэй” байх (Сайн мэдээний сэдвүүд, “Өршөөл,” topics.ChurchofJesusChrist.org).
Матай 5:8	Зүрхэндээ цэвэр ариун байх. “Их Эзэнийг хайрладаг, Түүнийг дагаж, зарлигуудыг нь сахихыг эрэлхийлдэг, журамт амьдралаар амьдрахыг хичээн, эцсээ хүртэл үнэнч хэвээр үлддэг хүмүүсийн нэг байхыг хэлнэ. Зүрхэндээ цэвэр ариун хүмүүс нь ёс суртахуунгүй хүсэл, үйлдлээс өөрсдийгөө хол байлгахын тулд бодол санаагаа хянадаг хүмүүс юм” (Sheldon F. Child, “Words of Jesus: Chastity,” <i>Ensign</i> эсвэл <i>Liahona</i> , Jan. 2003, 44).
Матай 5:9	Амар тайвныг тогтоогч байх. “Хүмүүс ялгаатай талыг нь олж хараад байдаг бол нийтлэг зүйлийг нь олоход тэдэнд туслах” явдал юм (Хэнри Б.Айринг, “ <i>Санваарт суралцахуй</i> ,” <i>Ensign</i> , May 2011, 63 эсвэл 2011 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 67).
Матай 5:10-12	Зөв байдлын төлөө хавчигдах. Доромжлуулж, доог тохуу болсон ч Есүс Христийг болон Түүний сургаалыг дагаж, хамгаалахад бэлэн байх.